

[БАГАНУУР ХК]

ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

ДААТГАЛ

Тендер
шалгаруулалтын
дугаар:

БНХК/20240102109

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4.Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б. АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

V. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1.ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2.оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3.ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4.оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5.тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6.санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7.ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8.ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9.Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4.Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1.Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1.Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1.Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадлана. Үүнд:

16.1.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2.Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2.Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл

оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх

талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3.Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4.ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1.Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2.III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3.Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3.Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.4.Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт

ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол

V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1.Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

30. Арифметик алдааг залруулах

30.1.Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

32.1.1.ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

32.1.2.ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон

үнийн хөнгөлөлт тооцох;

32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;

32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;

32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.

32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:

32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;

32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

33. Тендерийг эрэмбэлэх

33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах

34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

35.Мэдэгдэл хүргүүлэх 35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

36.Гүйцэтгэлийн баталгаа 36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

37.Урьдчилгаа төлбөр 37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.

38.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах 38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

39.Тендер шалгаруулалтын гомдол 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
---------------------------------------	------------------------

ТШЗ 1.1	Захиалагч: "Багануур" ХК, Багануур дүүрэг, 1-р хороо, Үйлдвэрийн хэсэг, Улаанбаатар хот , Монгол улс
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: ДААТГАЛ
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: БНХК/20240103109
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц № 1: Уулын тоног төхөөрөмжийн даатгал Багц № 2: Хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал Багц № 3: Хүнд машин механизмын даатгал Багц № 4: Үйлчилгээний авто машины даатгал Багц № 5: Суурин тоног төхөөрөмжийн даатгал Багц № 6: Тэсэлгээний ажилчдын гэнэтийн ослын даатгал
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгөөр
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 110,101,300 төгрөг <ul style="list-style-type: none"> • Багц №1: Уулын тоног төхөөрөмжийн даатгал -11,971,610.00 төгрөг • Багц №2: Хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал -45,342,450.00 төгрөг • Багц №3: Хүнд машин механизмын даатгал -18,708,050.00 төгрөг • Багц №4: Үйлчилгээний авто машины даатгал – 11,020,490.00 төгрөг • Багц №5: Суурин тоног төхөөрөмжийн даатгал-4,429,610.00 төгрөг • Багц №6: Тэсэлгээний ажилчдын гэнэтийн ослын даатгал-1,595,000.00 төгрөг
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Багануур ХК Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг 1-р хороо, Үйлдвэрийн хэсэг хэсэг, "Багануур" ХК-ийн байр Утасны дугаар: 70210328 Цахим шуудангийн хаяг: bjsc@baganuurmine.mn Сонирхогч этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргаж болно. Тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээлэлтэй холбогдуулан захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах эрхтэй ба энэ нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг байна.

	<p>Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр хүсэлтийг тодруулгын хамт албан бичгээр гаргаж Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлнэ. Ийнхүү нийтэлсэн даруйд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно.</p> <p>Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэх үүрэгтэй.</p>
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Үгүй
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулгын хамт тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: Зөвшөөрөхгүй
ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: Шаардана</p> <ul style="list-style-type: none"> • Нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 4.2 тэрбум төгрөгөөс дээш байх • Тендер оролцогч нь 20 дээш аймагт салбартай байх \Санхүүгийн зохицуулах хорооны тодорхойлолтоор баталгаажуулах\ • Тендерт оролцогч нь өөрийн гэсэн шуурхай албатай байх • Сүүлийн 2 жилийн хохирлын харицаа 35 хувиас дээш байх
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: Шаардана</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзнэ. • Дүрмийн сан, нөөцийн сан нь СЗХ -с гаргасан тогтоолын дагуу шаардлага хангаж байх /Холбогдох нотлох баримтыг ирүүлэх/ • Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана • Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь багцын төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна. • Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Багцын батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - 2022, 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн Санхүүгийн зохицуулах хорооны дүгнэлт ирүүлнэ. - Санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт

	<p>оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <ul style="list-style-type: none"> - Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээний нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: - Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ <ul style="list-style-type: none"> - Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн - тодорхойлолт ирүүлнэ. /Харилцагч банкны судлан үзэж зээл олгох боломжтой тухай тодорхойлолтыг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй/
<p>ТШЗ 19.1</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: Шаардахгүй</p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: Шаардана</p> <p>Гэрээг хэрэгжүүлэхэд санал болгож буй удирдах болон голлох боловсон хүчин нь даатгалын салбарт 3-с доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх.</p> <p>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардахгүй</p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: Шаардана</p> <p>Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын аль нэг жилд нэг удаа багцын төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн байх.</p> <ul style="list-style-type: none"> • Гэрээний хуулбар, <p>Ижил төстэй ажилд даатгалын үйлчилгээ үзүүлж байсан туршлагыг тооцно.</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардахгүй</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: Шаардахгүй</p>
<p>ТШЗ 19.2</p>	<p>Ижил төстэй гэрээний туршлага: 2022, 2023 оны аль нэг жилд багцын төрөл тус бүрд орсон даатгалын үйлчилгээ үзүүлсэн 1 гэрээний хуулбар, гэрээ тус бүрийн гэрээ дүгнэсэн акт мөн өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлэх. Багцад хамаарах даатгалын төрөл тус бүрийн үнэлгээ нь:</p> <ul style="list-style-type: none"> - Багц 1 Уулын тоног төхөөрөмжийн даатгал -7,352,904,852 төгрөг - Багц 2 Хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал -24,247,301,428 төгрөг - Багц 3 Хүнд машин механизмын даатгал -11,338,214,171 төгрөг - Багц 4 Үйлчилгээний авто машины даатгал – 834,885,000 төгрөг - Багц 5 Суурин тоног төхөөрөмжийн даатгал – 2,516,822,849 төгрөг - Багц 6 Тэсэлгээний ажилчдын гэнэтийн ослын даатгал – 120,833,350 төгрөг
<p>ТШЗ 19.3</p>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Шаардана</p> <p>Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх / Хүчин төгөлдөр хугацаа бүхий/</p>

	<p>Тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гэрээнд заасан гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <p>Тусгай зөвшөөрөл, үйлчилгээ үзүүлэх албан ёсны эрхийн гэрчилгээний хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв хугацаа дууссан бол эрх бүхий байгууллагын хугацааг сунгасан тухай шийдвэрийг ирүүлнэ.</p>
ТШЗ 21.4	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: Тохируулахгүй тогтмол байна
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн:</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2.багцтай тендер шалгаруулалтын тухайн багцын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол тендерийн баталгаа шаардана гэж заасан байдаг. Тус тендерийн багц тус бүрийн төсөвт өртөг 100 сая төгрөгөөс хэтрээгүй тул тендерийн баталгаа шаардахгүй болно.</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. Татварын байгууллагын тодорхойлолт цахимаар /Тендер нээсэн өдрийн байдлаар өр төлбөргүй байх/ 3. Нийгмийн даатгалын тодорхойлолт цахимаар /Тендер нээсэн өдрөөр өр төлбөргүй байх/ 4. Иргэний хэргийн шүүхийн тодорхойлолт ирүүлэх. /Сүүлийн 1 жилийн тодорхойлолт, Хэрэв хариуцагчаар оролцож байсан бол холбогдох шүүхийн шийдвэрийг заавал ирүүлнэ/ 5. ШШГЕГ-ын тодорхойлолт цахимаар Дээрх тодорхойлолтуудыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. 6. Багануур дүүрэгт өөрийн салбартай байх /Холбогдох нотлох баримт ирүүлэх/ <p>Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 12-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 10 дүгээр сарын 15-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 00 минут</p>

ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 10 дүгээр сарын 15-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Худалдан авах ажиллагааны tender.gov.mn системээр цахим нээлт хийнэ.
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Ашиглахгүй”
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 36.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: Үгүй

Үйлчилгээний нэр : УУЛЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ДААТГАЛ

Нэг. Зорилго: “Багануур” ХК-ийн эзэмшлийн, алхагч болон шууд утгуурт экскаватор, өрмийн машиныг ашиглах явцад хөрөнгөнд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, эд хөрөнгөнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА хохирлыг нөхөн төлөх санхүүгийн

эх үүсвэрийг баталгаажуулах зорилготой.

Хоёр. Даатгал үйлчлэх газар нутаг: Улаанбаатар хотын Багануур дүүрэг, “Багануур” ХК -ийн үйлдвэрийн талбайд

Гурав. Даатгалын гэрээний төсөл:

- 3.1 Тендер оролцогч дараах нөхцөл болон шаардлагын дагуу даатгалын гэрээний төслийг бэлтгэж ирүүлнэ. Гэрээ нь Монгол Улсын Иргэний, Даатгалын тухай, Жолоочын даатгалын тухай, Жолоочын даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн, даатгалын хамгаалалтын хувьд үйлчилгээний зорилгоо бүрэн хадгалсан, гэрээний үүрэг зохих ёсоор бүрэн биелүүлэхээр зохицуулагдсан байна.
- 3.2 Гэрээний төсөлд даатгалын хураамжийн дүн, хураамжийн хувийг **** тэмдгээр илэрхийлж нууцалсан байна.
- 3.3 Даатгалын гэрээнд зайлшгүй хэрэглэгдэх нэр томъёог бүрэн тусгасан байх
- 3.4 Тендерт оролцогч нь даатгалын гэрээгээр хүлээх Даатгагч, Даатгуулагчийн эрх үүргийн тодорхой заасан байх

Дөрөв. Даатгалын зүйл, даатгалын үнэлгээ:

Тендерт оролцогч нь Хүснэгт1-д үзүүлсэн даатгалын гэрээний зүйл, даатгалын үнэлгээ хариуцлагын үнэлгээний хэмжээг үндэслэн хураамжийн хэмжээг тодорхойлж ирүүлнэ.

Хүснэгт 1

	Даатгалын зүйл	Тоо ширхэг	Даатгалын үнэлгээ
1	Уулын тоног төхөөрөмж	21	7,352,904,852.00

Тав. Даатгуулах эрсдэл:

- 1.1 "Багануур" ХК-ийн эзэмшлийн, алхагч болон шууд утгуурт экскаватор, тэсэлгээний өрмийн машинд "Багануур" ХК-ийн өөрийн эзэмшлийн бүсэд байгалийн гаралтай/техникийн зогсоол болон ашиглаж байх үеийн үер, газар хөдлөлт, аадар бороо, аянга, мөндөр, хүчит салхи гэх мэт/ бүх эрсдлээс үүссэн хохирлыг 100 % төлөх
- 1.2 "Багануур" ХК-ийн эзэмшлийн, алхагч болон шууд хутгуурт экскаватор, тэсэлгээний өрмийн машинд "Багануур" ХК-ийн өөрийн эзэмшлийн бүсэд тэслэх дэлбэрэлтэд өртөх, технологийн үйл ажиллагаанаас хамаарсан техникийн осол аваар, тэсэлгээний процесс, нүүрсний гал, мөргөцгийн болон овоолгын гулсалт, нуралтаас үүссэн хохирлыг 100% төлөх
- 1.3 "Багануур" ХК-ийн эзэмшлийн, алхагч болон шууд хутгуурт экскаватор, тэсэлгээний өрмийн машинд "Багануур" ХК-ийн өөрийн эзэмшлийн бүсэд цахилгааны гэмтлээс гаралтай цахилгаан эрчим хүчний хэлбэлзлийн улмаас үүсэх эрсдлийн хохирлыг 100 % төлөх
- 1.4 "Багануур" ХК-ийн эзэмшлийн, алхагч болон шууд хутгуурт экскаватор, тэсэлгээний өрмийн машинд "Багануур" ХК-ийн өөрийн эзэмшлийн бүсэд техникийн осол аваар гарах хохирлыг 100 % төлөх
- 1.5 Уурхайд гарсан осол аюулыг бууруулах арга хэмжээний үед даатгалын зүйлд учирсан хохирлыг 100 % төлөх
- 1.6 Даатгалын зүйлд ослоос шалтгаалсан механик эвдрэлийг сэргээх зардлын эрсдэлийг 100 % төлөх

Зургаа. Хохирлыг оношлох, үнэлэх, засварлах, нөхөн төлөх зарчим хугацаа:

- 6.1 Оношлогоо: Уулын тоног төхөөрөмжийн даатгалын гэрээгээр учирсан хохирлыг хөндлөнгийн мэргэжлийн албан ёсны оношлогооны төв, төлөөлөгчийн газраар

/дистрибутер/ оношлуулна.

- 6.2 Хохирлыг үнэлэх: Уулын тоног төхөөрөмжийг чанарын өндөр түвшинд засварлах, агрегатыг солих үнэлгээг албан ёсны төлөөлөгчийн газраар /дистрибутер/ гүйцэтгүүлнэ.
- 6.3 Засварлах, эд ангийг солих орлуулах: Эвдэрч даатгалын тохиолдол үүссэн эд ангийг чанарын ижил түвшинд сольж өгч болно. Даатгагчаас хохирсон механизмыг засварт оруулж хэвийн байдалд оруулах ажлыг өөрөө хариуцан хийх тохиолдолд 1 жилийн хугацаанд засварын баталгаа өгөх, засварын дараа албан ёсны оношлогоонд оруулж хүлээлцэх асуудлыг гэрээнд тусгана.
- 6.4 Хохирлыг даатгагчаас хариуцан засварлах тохиолдолд хугацаа нь 45 хоногоос хэтрэхгүй бөгөөд солигдох техник эд ангийг сонгох, захиалахад захиалгатай хэлэлцэх бичгээр зөвшөөрөл авна.
- 6.5 Даатгагч нь албан ёсны дистрибутерийн газраар хохирлыг сэргээх, засварлуулах зардлын нэхэмжлэлийг үндэслэн мөнгөн хэлбэрээр нөхөн төлбөрийг төлнө.
- 6.6 Эвдэрч даатгалын тохиолдол үүссэн уулын тоног төхөөрөмжийг засварын газарт хүргэх зардлыг даатгалаар бүрэн төлнө.
- 6.7 Гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлыг оношлох, хохирлын хэмжээг тогтоох хүртэл осол болсноос хойш 48 цагт багтаан даатгалын үнэлгээний 50 хувь хүртэл хэмжээнд урьдчилгаа нөхөн төлөх, хохирлыг бүрэн нөхөн төлөх хугацаа нь даатгалын нэхэмжлэлийг гаргаснаас хойш ажлын 10 хоногт багтах заалтыг гэрээнд тусгана.

Долоо. Даатгалын хамгаалалтын нөхцөл:

- 7.1 Уулын тоног төхөөрөмжид учирсан хохирлыг даатгагчаас 90-100% нөхөн төлөх нөхцөлөөр санал ирүүлэх бөгөөд эрсдэл тус бүрд хохирлыг нөхөн төлөх хувь хэмжээ нь тендерийн үнийн саналд нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг болно.
- 7.2 Тендерт оролцогч нь даатгалын нэг удаагийн тохиолдолд даатгуулагч хариуцах хохирлын хэмжээг 5 хувиас хэтрүүлэхгүй байх

Найм. Даатгалын гэрээний хугацаа, цуцлах, өөрчлөлт оруулах, хариуцлага

- 8.1 Тендерт оролцогч нь даатгалын гэрээг дүгнэх, өөрчлөлт оруулах тохиолдолд хураамжийн буцаалтыг хэрхэн хийх, суутгалын зарчмыг тодорхой зааж тусгасан байна.
- 8.2 Гэрээний төсөлд даатгагч хохирлыг нөхөн төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгээс хоног тутам 0.5 хувьтай тэнцэх алдангийг тооцож төлөх заалтыг тусгана.
- 8.3 Гэрээг хариуцан ажиллах боловсон хүчин нь даатгалын салбарт ажилласан туршлагатай удирдах түвшний албан тушаалтан байх бөгөөд ажилтны нэр, танилцуулга, мэргэшсэн байдлыг хавсарган ирүүлнэ.

Ес. Нөхөн төлбөрийн нөхцөлд тавигдах шаардлага

- 9.1 Даатгалын гэрээгээр нөхөн төлбөрт хамаарахгүй заалт нь даатгах үйлчилгээний зорилгыг үгүйсгээгүй, захиалагчийн даатгуулах зорилгыг бүрэн хэрэгжих боломжоор хангасан байх
- 9.2 Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргахад бүрдүүлэх шаардагатай бичиг баримтыг жагсаах, /шүүхийн шийдвэр харгалзахгүйгээр ажилтны буруутай үйлдэл болохыг хүлээн зөвшөөрөх зарчим, шийдэгдэх нөхөн төлбөрийн хэмжээ, хугацааг заах/
- 9.3 Тендерт оролцогч нь Захиалагчийн даатгал хариуцсан ажилтанг сургалтанд хамруулах саналыг гэрээнд тусгасан байх
- 9.4 Даатгагч хохирлыг бууруулах арга хэмжээний зардлыг даатгалаар нөхөн төлөх хэмжээ, хохирлын үед авах арга хэмжээний талаар тусгайлан заасан байх

Арав. Голлох боловсон хүчин болон туслан гүйцэтгэгчдийн мэдээлэл

- 10.1 Удирдах болон голлох албан тушаалтан /Даатгалын салбарт 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх/

д/д	Даатгах хөрөнгийн жагсаалт	Ашиглалтанд орсон
1	Экскаватор ЭШ 20/90 '15	1985
2	Экскаватор ЭШ 10/70 '50	2006
3	Экскаватор ЭШ 13/50 '35	1987
4	Экскаватор ЭШ 10/70 '61	1991

5	Экскаватор 10/70 1492	1988
6	Экскаватор 10и 1 33	1995
7	Экскаватор ЭКГ-10 1476	2010
8	Экскаватор 10и 11941	1988
9	Экскаватор 8и 12250	1989
10	Экскаватор 8и 12074	1993
11	Экскаватор 8и 11946	1988
12	Экскаватор ЭКГ 4У №323	1988
13	Экскаватор ЭКГ5А 1581	1993
14	Экскаватор ЭКГ5А 11426	2006
